

**“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2026 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН**

2026 оны 03 дугаар сарын 27

Улаанбаатар хот

1. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Erp.Ulaanbaatar.mn өргөдөл, гомдлын программд 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 13 өргөдөл, гомдол бүртгэгдсэн. Үүнд:

- Иргэнээс 11 өргөдөл,
- Ажилтан, албан хаагчаас 2 өргөдөл.

Үүнээс 84 хувь буюу 11 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 15 хувь буюу 2 өргөдөл, гомдол шийдвэрлэх шатандаа судлагдаж байна.

Тайлант хугацаанд өдөрт нь багтаан хүлээн аваагүй 1, явцын тэмдэглэл хөтлөөгүй 1 зөрчил тус тус бүртгэгдсэн.

Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол бүртгэгдээгүй.

Өргөдөл, гомдлыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал 31,6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2026 оны өргөдөл, гомдлыг 2025 онтой харьцуулбал:



Тайлант хугацаанд “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдөр газрын даргаар батлуулж, төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- Албан хаагчаас 2 хүсэлт ирүүлснээс:

Шийдвэрлэгдсэн: Цалингүй чөлөө хүссэн-1, Жирэмсний амралт авах тухай-1 хүсэлт ирүүлснийг Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Түвшинжаргал тухай бүрт нь газрын даргын тушаалаар шийдвэрлэн ажиллав.

- Иргэнээс 11 өргөдөл, гомдол ирүүлсэнээс:

Архивын лавлагаа мэдээлэл, Хот байгуулалт ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тухай, Сууц өмчдөгчдийн холбоодын үйл ажиллагааны тухай, Барилга байгууламжийн маргаантай асуудлыг шийдвэрлэх тухай, Санхүүжилтийн тухай, Нийтийн эзэмшлийн гудамж талбайн болон ТҮЦ павильон, ил задгай худалдаа, үйлчилгээний тухай, Халтиргаа, гулгаа цэвэрлэгээний тухай, Газрын маргаантай асуудлыг шийдвэрлэх тухай, Барилга байгууламж буулгах тухай, Нийслэлийн Өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны тухай. Барилга

байгууламж өргөтгөх барих тухай ирүүлснийг 11 өргөдөл, гомдлыг шийдвэрлэгдэж, 2 өргөдөл, гомдол судлагдаж байна.

ТАНИЛЦСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.ГҮРБАДАМ

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН



А.СОЛОНГО

ТАЙЛАН БИЧСЭН:
ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР ХАМТЫН АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Т.ИЧИНХОРЛОО